



2026 оны 8 дугаар сарын 11-ний өдөр

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Баялгийн сангийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.58 дахь заалтад ““Үндэсний баялгийн сангийн төсөв” гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу төрөлжсөн сан бүрд төвлөрүүлж, зарцуулах, хуримтлал үүсгэх зорилгоор тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1.а дахь заалтад “Ирээдүйн өв сангийн эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь” гэж тус тус заасан нь Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан хүний эрх, эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөөг хангах, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эдийн засгийн тогтвортой осолтийг дэмжих, шударга өрсөлдөөнийг хамгаалах, технологи, инновацыг хөгжүүлэх, төрийн оролцоог зохистой түвшинд хязгаарлах, өсөлтийн үр өгөөжийг иргэдэд бодитоор хүртээх зорилгоор “Чөлөөлье” үндэсний санаачилгыг

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлж, энэ хүрээнд 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 285 дугаар тогтоолоор "Чөлөөлье" үндэсний санаачилгыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхлээд байна.

Энэхүү төлөвлөгөө нь (I) эдийн засгийн чөлөөлөлт, (II) ногоон чөлөөлөлт, (III) авлигын эсрэг чөлөөлөлт, (IV) эрх зүйн чөлөөлөлт гэсэн үндсэн дөрвөн багц арга хэмжээг багтаасан ба хувийн хэвшил, баялаг бүтээгч, хөрөнгө оруулагчдыг дэмжих болон ашигт малтмалын хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх, хариуцлагатай хайгуулын үйл ажиллагааг дэмжих замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийн төслүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, экспортын бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэхтэй холбогдсон арга хэмжээг эдийн засгийн чөлөөлөлтийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит компаниудын засаглал, бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлтийг богино хугацаанд үр дүнтэй авч хэрэгжүүлэхээр тодорхой арга хэмжээнүүдийг тусгаж, үүний эхлэл болгон “Эрдэнэс Монгол” нэгдлийг олон улсын сайн засаглалын зарчим, стандартад нийцүүлж, үндэсний хэмжээний хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлагын чиг үүрэг бүхий “Чингис хаан баялгийн сан нэгдэл” ХХК болгон өөрчлөн зохион байгуулах шийдвэрийг гаргаад байна.

Ингэснээр, Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Чөлөөлье” санаачилгын төлөвлөгөөний 1.3-т тусгагдсан Төрийн өмчит компаниудын хувьцааны багцын удирдлагыг олон улсын хөрөнгө оруулалтын мэргэжлийн байгууллагад санал болгож, хувьцааг хөрөнгийн биржид нээлттэй арилжаалах суурийг бүрдүүлээд байна.

Тус арга хэмжээний хүрээнд “Чингис хаан баялгийн сан нэгдэл” ХХК-ийн харьяанд шинээр төрийн өмчит компани үүсгэн байгуулахгүй байх зарчмыг баримтлан үндэсний хэмжээний хөрөнгө оруулалтын санг төрийн 100 хувийн эзэмшлийн компани хэлбэрээр байгуулж, төрийн өмчит компаниудын хувьцааны тодорхой хэсгийг тус санд төвлөрүүлэн олон улсын нэр хүндтэй хөрөнгө оруулалтын менежментийн компаниар удирдуулах бэлтгэл ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж эхлээд байна.

Тухайлбал, олон улсын нэр хүнд бүхий 12 хөрөнгө оруулалтын менежментийн компаниудад хамтран ажиллах санал хүргүүлж, Франклин Темплетон болон БлэкРок зэрэг компаниудаас хамтран ажиллах санал ирүүлсний дагуу Франклин Темплетон компанитай харилцан ойлголцлын санамж бичгийг Монгол Улсын Засгийн газрын түвшинд байгуулж, ойрын хугацаанд БлэкРок-той санамж бичиг байгуулахаар тус тус ажиллаж байна.

Монгол Улсын хувьд хөрөнгийн зах зээлийн хэмжээ харьцангуй жижиг, олон улсын хөрөнгө оруулагчдын сонирхлыг дангаараа татахуйц томоохон компаниудын тоо хязгаарлагдмал тул хөрөнгө оруулалтын сан байгуулж олон улсын нэр хүнд

бүхий мэргэжлийн хөрөнгийн удирдлагын байгууллагаар удирдуулах замаар олон салбарын компаниудын хувьцааг нэг багцад нэгтгэх нь илүү төрөлжсөн, тэнцвэртэй, хөрөнгө оруулалтын хувьд сонирхол татахуйц бүтээгдэхүүнийг дотоодын болон олон улсын зах зээлд санал болгох боломж бүрдэнэ.

Хоёрдугаарт, Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Чөлөөлье” санаачилгын хүрээнд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбар дахь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос Үндэсний баялгийн санд хуваарилаад үлдэх хэсгийг улсын төсөвт ногдол ашгийн орлого хэлбэрээр төвлөрүүлэх, мөн зарим томоохон төсөл, хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Тухайлбал, “Чөлөөлье” санаачилгын төлөвлөгөөнд тусгагдсан гангийн цогцолбор, нүүрс-пиролизын үйлдвэр, зэс боловсруулах үйлдвэрийн цогцолбор барих болон газрын тос боловсруулах үйлдвэр барих төслүүдийг эрчимжүүлэхээс гадна Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих, Зөөвч-Овоо төслийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эхлүүлэх болон Хэрлэн-Тооно гадаргын усыг хуримтлуулан ашиглах, Хойд бүргэд алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төслүүдийн үйл ажиллагааг эхлүүлж, шаардлагатай хөрөнгө оруулалт татах, төслийн хэрэгжилтийн явцад мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг “Чингис хаан баялгийн сан нэгдэл” ХХК хариуцан зохион байгуулж байна.

Дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлснээр төрийн өмчит компаниудын засаглал сайжрах нөхцөл бүрдэх ба мөн томоохон төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулснаар “Чингис хаан баялгийн сан нэгдэл” ХХК-ийн үндсэн үйл ажиллагааний орлого нэмэгдэх, цаашлаад Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад заасан “орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд”-ийн хувьд Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх орлогын хэмжээ бодитойгоор нэмэгдэх ач холбогдолтой гэж үзсэн.

Мөн Монгол Улсын Засгийн газрын “Чөлөөлье” үндэсний санаачилгын төлөвлөгөөнд тусгагдсан ‘эрх зүйн чөлөөлөлт’-ийн дагуу хийгдэж буй арга хэмжээний хүрээнд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль зэрэг цогц хуулиуд хэрэгжиж эхэлснээр гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх, ашигт малтмалын эрэлт, хайгуул эрчимжих, эрдэс баялгийн экспорт өсөх төлөвтэй байна.

Гуравдугаарт, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээхээр Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн нэг болох Ирээдүйн өв санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувийг төвлөрүүлэхээр хуульчилсан.

Энэхүү зохицуулалтын хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нүүрсний эрэлт тогтвортой хадгалагдаж, хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадал болон тээвэр, логистикийн үйл ажиллагаа сайжирч байгаатай холбоотойгоор нүүрсний экспорт өсөх төлөвтэй байна. Түүнчлэн Оюу толгойн гүний уурхайн зэсийн баяжмал дахь цэвэр зэс, алтны агуулга үргэлжлэн нэмэгдсэнээр зэсийн баяжмалын экспорт мөн өсөж уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2026 онд 17.6 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Дээр дурдсан нөхцөл байдлын улмаас Ирээдүйн өв санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс орох орлогын төсөөллийг гадаадын зах зээл, дотоодын экспортын төсөөлөлтэй уялдуулах шаардлага үүсэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 3 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр зүйлд Үндэсний баялгийн санд 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, хуримтлуулах дүнгийн өөрчлөлтийн талаар;

Хоёрдугаар зүйлд Ирээдүйн өв санд 2026 онд орох орлогын өөрчлөлттэй холбоотойгоор Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийн талаар;

Гуравдугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудад 2026 оны төсвийн жилд орлого төвлөрүүлж хуримтлуулах, ингэснээр Үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг хуваарилах Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, шинэчлэн

найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---